



**ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН**

2025

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

2025 оны эхний хагас бол Монгол улсын хөрөнгийн зах зээлд боломж ба өөрчлөлтийн зааг болсон онцлог үе байлаа. Сүүлийн жилүүдийн глобаль хэлбэлзэлтэй харьцуулахад энэ оны эхний хагаст тодорхойгүй байдал буурч, хөрөнгө оруулагчид илүү зоримог, илүү системтэй шийдвэрүүд гаргах боломж бүрдсэн нь зах зээлийн сэтгэл зүйд мэдэгдэхүйц эерэг дохио өглөө.

Дотоодын эдийн засаг экспортын орлогын өсөлт, гадаад худалдааны ашиг, төсвийн гүйцэтгэлийн сайжрал зэрэг үзүүлэлтүүдээр дэмжигдэж, хөрөнгө оруулалтын орчин харьцангуй тогтвортой байв. Хэдийгээр инфляц, ханшийн хэлбэлзэл бүрэн арилаагүй ч өмнөх оныхоос эрс багассан нь дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлд эерэгээр нөлөөлсөн.

Үндэсний Хувьчлалын Сан нь энэхүү шинэ нөхцөлд идэвхтэй, сонголтод суурилсан хөрөнгө оруулалтын арга барилаа хадгалж, төрийн өмчит болон хувийн секторын стратегийн ач холбогдол бүхий компанийн үнэт цаасанд чиглэсэн бодлогоо улам гүнзгийрүүлээ. Бид зах зээлийн түр хугацааны хэлбэлзлийг хөөхөөс илүүтэйгээр компанийн үнэт зүйл, өсөлтийн суурь хүчин зүйлсэд үндэслэн шийдвэр гаргасаар байна.

Сангийн эзэмшиж буй багцын доторх зарим хувьцаа богино хугацаанд үнэ уналттай байсныг үл харгалзан тухайн компаниудын үйл ажиллагааны чанар, санхүүгийн тогтвортой байдал, урт хугацааны өсөлтийн потенциал нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хамгаалах үндсэн баталгаа байсаар байна.

2025 оны үлдсэн хагас жилд хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн санхүүгийн хэрэгслүүд, хөрөнгө оруулалтын платформууд, олон улсын хамтын ажиллагааны боломжууд бий болох хүлээлттэй байна. Түүнчлэн, Засгийн газрын зүгээс хууль, зохицуулалтын орчныг илүү тогтвортой болгох алхмууд хийх нь хөрөнгө оруулалтын урсгалыг тэлэх гол суурь нөхцөл болно гэж бид харж байна.

Үндэсний Хувьчлалын Сан нь Монгол улсын эдийн засгийн ирээдүйд итгэлтэй хандаж, бодлогын тууштай байдал, өгөөжийн тогтвортой байдал, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг нэгдүгээрт тавих зарчмаар ажиллаж байна. Хувьчлалын шинэ давалгаа, зах зээлийн шинэ боломжуудын үед бид хариуцлагатай хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн удирдан чиглүүлж ажиллах болно.

Сангийн менежер

У.Сүхдарь

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, төрийн өмчит хувьцаат компаниудын хувьчлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 10 дугаар сард хамтын хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээр байгуулагдсан билээ. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, зах зээлийн огцом хэлбэлзэл зэрэг сорилтууд тулгарсан ч, манай сан мэргэжлийн удирдлага, хөрөнгө оруулалтын нягт төлөвлөлтөөр дамжуулан тогтвортой өсөлтөө хадгалсаар ирлээ.
- 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮6.78 тэрбумд хүрч, анхны хөрөнгөтэй харьцуулахад 35.7%-ийн өсөлт үзүүлсэн байна. 2025 оны эхэнтэй харьцуулахад нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ ₮135.67 болж, 1.66%-иар өссөн нь зах зээлийн хэлбэлзэлтэй үед ч сангийн бодлого оновчтой байсныг харуулж байна. Энэ хугацаанд бид хөрөнгө оруулалтын стратегидаа дунд болон урт хугацаанд чиглэсэн тодорхой шинэчлэлүүдийг хийсэн. Тухайлбал, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй зарим компанийн багц дахь эзлэх хувийг бууруулах замаар эрсдэлийг хязгаарлаж, оронд нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК (MSE: ERDN, TSX: ERD)-ийн хувьцааг багцын 10 хувьд хүргэж нэмэгдүүлсэн. Энэхүү шийдвэр нь уул уурхайн салбар дахь өсөлтийн потенциал болон гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй байдалд үндэслэсэн судалгаа, тооцоололд тулгуурласан юм.
- Цаашид манай хамт олон үнэ цэнийг нэмэгдүүлж, тогтвортой өсөлт үзүүлэх чадвартай хөрөнгөд төвлөрсөн хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчдынхаа урт хугацааны өгөөжийг дээд түвшинд хүргэх зорилт тавин ажиллах болно.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2021	2022	2023	2024	2025Q2
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж	91.2%	-24.4%	-10.63%	7.21%	1.66%
ТОП-20-ийн өгөөж	130%	-15.4%	10.31%	23.79%	-4.29%
Хадгаламжийн хүү	~9%	10.3%	12.00%	11.77%	9.76%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр
ХОС

Гаргасан нэгж эрх
50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
7,111

Нэгж эрхийн хаалтын ханш
₮96.16

Зах зээлийн үнэлгээ
₮4.80 тэрбум

Жилийн арилжааны эргэлт
₮174.6 сая

Нэгж эрхийн NAV
₮135.67

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮6.78 тэрбум

ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Батбилэгийн Золбоо

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн дарга**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн
Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн
ТУЗ-ийн дарга



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

Албан тушаал: “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн, Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК”
ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Чулуунбаатарын Хандаа

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч

Албан тушаал: ТУЗ-ийн ердийн гишүүн



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн ТУЗ-
ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Албан тушаал: , МУИС, Санхүүгийн тэнхимийн
ахлах багш



Батхүү Ариунболд

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Интергрупп Интернэйшнл ХХК”
Санхүү эрхэлсэн захирал

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



Угтахбаяр Сүхдарь

Мэргэжил: Санхүү, Хөрөнгө оруулалт

Албан тушаал: “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн
сангийн менежер

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэчилсэн журмын дагуу Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг билээ.


НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2024 оны эцсийн байдлаар Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,882 байсан бол оны 2025 оны эхний хагас жилийн байдлаар 7,111-д хүрч 3.3%-иар өссөн байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо тогтвортойгоор өсөж байгааг харвал сангийн үйл ажиллагаа хэвийн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ буураагүй байгааг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ ХК	5,229,786	10.5%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС	3,415,499	6.8%
ТУЛГА	2,999,610	6.0%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК	2,507,445	5.0%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ	2,500,000	5.0%
АРД КРЕДИТ ББСБ	1,558,998	3.1%
БОГД БАНК	1,371,500	2.7%
МАНДАХБАЯР	1,000,000	2.0%
НАРАНБАТ	1,000,000	2.0%
ЦЭРЭНДОЛГОР	807,141	1.6%
Бусад 7,101	27,610,021	55.2%
Нийт	50,000,000	100.00%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


ХОС нь 2025 оны эхний хагас жилд гадаад улсын бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2025 оны эхний хагаст 6.78 тэрбум төгрөгт хүрч 1.66%-иар өссөн бол зах зээлийн үнэлгээ нь 4.80 тэрбум төгрөгт хүрч 15.2%-иар унасан байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 35.7%-иар өсөөд байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
06/30/2025	96.16	135.67
Оны эхнээс %	-15.26%	1.66%
Сан нээгдсэнээс хойш	-3.84%	35.67%
2025 оны доод дээд	80.10-113.48	120.86-135.67

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХОС-ийн хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй компанийн хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба багцын дийлэнх буюу 80 орчим хувийг дангаар бүрдүүлж байна. Тайлант хугацаанд гадаад дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан дотоод болон гадаадын тодорхой хувьцаануудаа зарж гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой хувьцаануудаар багцаа сэлгэн хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.

2025 оны 06 дугаар сарын 30-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 32 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 24 нь дотоодын хувьцаа, 8 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 11, өргөн хэрэглээний 5, түүхий эдийн 4, аж үйлдвэрийн 6, тогтмол бус хэрэглээний 3, технологийн 3, харилцаа холбооны салбарын 1 хувьцаануудаас багц бүрджээ.

Хувьцааны багц, эдийн засгийн салбараар (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЗАРДАЛ

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 6,503 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 138.3 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн үнэлгээнээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2025 оны эхний хагас жилд 2.04% байна.

Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 87%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Mean	0.000324148
Standard Error	0.000325922
Median	0
Mode	0
Standard Deviation	0.011100508
Sample Variance	0.000123221
Kurtosis	6.195698674
Skewness	0.957056715
Range	0.12642932
Minimum	-0.053319189
Maximum	0.073110131
Sum	0.37601165
Count	1160


Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний 1,160 өдрийн мэдээлэлд тулгуурлан эрсдэлийн үзүүлэлтийг тооцоолбол дээрх байдалтай байна.

Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний өдрийн стандарт хазайлт нь өндөр байх тусам хөрөнгө оруулагчид өндөр эрсдэл хүлээж байгааг илэрхийлдэг. Олон улсад өдрийн стандарт хазайлтыг 2%-с дээш байвал эрсдэл өндөр, 1%-с бага байвал эрсдэл бага гэж үздэг бөгөөд Үндэсний Хувьчлалын сангийн хувьд өдрийн стандарт хазайлт 1.11% байна.

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог. ХОС-ийн нэгж эрхийн арилжааны эргэлт 2025 оны эхний хагаст ₮174.6 сая байгаа ба нийт 1.92 сая ширхэг нэгж эрх арилжаалагдсан ба энэ нь сангийн 3.86 хувь гар сэлгэсэн байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАЙЛАН

Ард Менежмент ҮЦК ХХК (цаашид “Ард Менежмент” гэх) нь өндөр өгөөжтэй, ирээдүйд хурдтай өсөх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Ард Менежмент нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, 2016 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх болсон.

Ард Менежмент нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр ХОС-той байгуулсан №20/14 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулж байна.

2025 оны эхний хагаст Ард Менежментээс ХОС-д гэрээний дагуу үзүүлсэн ажил үйлчилгээг тоймлон харуулвал:

Хөрөнгө итгэмжлэн удирдах

- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэж байна.

ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

- ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайланг гаргаж хүргүүлэв.
- ХОС-ийн тайлан мэдээнүүдийг гаргаж, тайлагнахтай холбоотой Голомт Банкны кастодиан банкны газар, МХБ, СЗХ-той хамтран ажиллаж, МХБ болон Ард Менежментийн цахим сайтуудад Сангийн нэгж эрхийн арилжаа, хөрөнгө оруулалтын талаар тогтмол мэдээг хүргэв.
- ХОС-ийн багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааны захиалга хийх, төлбөр тооцоо төлөх, кастодиантай мэдээлэл солилцох ажлыг тогтмол гүйцэтгэж байна.
- Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сан болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн У.Сүхдарь нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаа. Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд хөрөнгө оруулалтын багцыг удирдах, сангийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийт 1,143.4 сая төгрөгийн нийт 330 хэлцэл хийгдсэн ба 15 хувьцаагаар дамжуулан хийлээ.

Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.

Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтууд хийдэг ба хэтэрхий өндөр үнэлэгдсэн тодорхой хэдэн хувьцаануудаас гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой дунд хугацааны хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Хагас жил бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банкинд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 6,879 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 6,838 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2024 оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө 13.63%, цэвэр хөрөнгийн дүн 14.18%-ийн өсөлтийг тус тус үзүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН		Сая төгрөг	
Үзүүлэлт		2024 Q4	2025 Q2
Нийт хөрөнгө		6,800	6,879
Мөнгө		619	711
Санхүүгийн хөрөнгө /Бодит/		6,152	6,136
Авлага		16	19
Хойшлогдсон татварын хөрөнгө		13	13
Нийт өр төлбөр		45	41
Дансны өглөг		33	29
Хойшлогдсон татварын өр		12	12
Эздийн өмчийн дүн		6,755	6,838
Өмч		5,000	5,000
Хуримтлагдсан ашиг		1,755	1,838


ОРЛОГЫН ТАЙЛАН		Сая төгрөг	
Үзүүлэлт		2024 Q4	2025 Q2
Хүүгийн орлого		41	14
Ногдол ашгийн орлого		167	214
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз		428	39
Нийт ашиг (алдагдал)		636	267
ХОМК-ийн үйлчилгээний зардал		(153)	(75)
Кастодианы үйлчилгээний зардал		(23)	(9)
Бусад зардал		(77)	(99)
Нийт үйл ажиллагааны зардал		(253)	(183)
Татварын өмнөх ашиг		383	84
Хойшлогдсон татварын зардал		(3)	(0)
Тайлант үеийн цэвэр ашиг		380	84

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, уналт нь экспортын голлох түүхий эдийн олон улсын зах зээлийн үнэ, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, стратегийн томоохон төслүүдийн хэрэгжилттэй шууд уялдаатай байдаг. 2024 онд эдийн засаг 4.9 хувийн өсөлттэй гарсан бол 2025 оны эхний улиралд энэ өсөлт саарч, 2.4 хувьтай гарлаа.

Эдийн засгийн энэхүү 2.4 хувийн өсөлтөд дараах салбарууд эерэг нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

- * Хөдөө аж ахуйн салбар 1.0 нэгж хувь,
- * Бусад үйлчилгээний салбар 2.4 нэгж хувь,
- * Мэдээлэл, холбооны салбар 0.6 нэгж хувь,
- * Боловсруулах үйлдвэрлэл болон цахилгаан эрчим хүчний салбар тус бүр 0.2 нэгж хувь,
- Уул уурхайн салбар 0.1 нэгж хувь,
- Тээвэр, логиستيкийн салбар 1.2 нэгж хувь,
- Худалдааны салбар 0.6 нэгж хувь,
- * Цэвэр татварын өөрчлөлт 0.4 нэгж хувиар эдийн засгийн өсөлтийг сааруулсан сөрөг нөлөө үзүүлсэн байна.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


Монгол Улс 2025 оны эхний хагас жилд нийт 145 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.1 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүнээс экспорт 6.6 тэрбум ам.доллар, импорт 5.5 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.7% буюу 1.2 тэрбум ам.доллар, экспорт 16.6% буюу 1.3 тэрбум ам.доллар, тэнцэл 58.1% буюу 1.5 тэрбум ам.доллараар тус тус буурч, импорт 2.8% буюу 150.1 сая ам.доллараар өссөн байна.

Экспорт 2025 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллараар буурахад нүүрс 2.1 тэрбум ам.доллар, угаасан ноолуур 148 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 16.7 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин зэсийн хүдэр ба баяжмал 897.9 сая ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 55.9 сая ам.доллар, цайрын хүдэр, баяжмал 28.7 сая ам.доллараар өссөн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум доллар)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2025 оны эхний хагас жилд нийт 124 удаагийн үнэт цаасны арилжаагаар 324 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 59 хувиар, хоёрдогч зах зээлийн арилжаа 11.3 хувиар өссөн бол анхдагч зах зээлийн арилжаа 95.9 хувиар буурсан байна.


МХБ-н арилжааг арилжааны төрлөөр авч үзвэл нийт арилжааны 34.2 хувийг хувьцааны арилжаа, 1.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа, 46.6 хувийг бонд, хбүц-ийн арилжаа, 17.9 хувийг ЗГҮЦ-ны арилжаа бүрдүүлж байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар зах зээлийн үнэлгээ 12.1 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 6.2 хувийн уналт, өнгөрсөн оны мөн үеэс 7.5 хувийн өсөлтийг үзүүлээд байна

Улаанбаатар үнэт цаасны бирж дээр 2025 оны эхний хагас жилд 37 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 27 дахин өссөн байна.

Улаанбаатар үнэт цаасны биржийн арилжааг арилжааны төрлөөр авч үзвэл нийт арилжааны 1.7 хувийг хувьцааны арилжаа, 0.07 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа, 98.1 хувийг бонд, хбүц-ийн арилжаа бүрдүүлж байна.

МХБ-н арилжааны дүн, зах зээлийн үнэлгээ жил бүрийн эхний хагаст




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2025 оны эхний хагас жилд нийт 494 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжаа зохион байгуулагдаж үүнээс 174 удаагийн арилжаа амжилттай болсон байна. Нийт арилжааны 55.5 хувийг төмрийн хүдэр, баяжмалын арилжаа, 43.8 хувийг нүүрсний арилжаа, 0.4 хувийг зэсийн арилжаа, 0.3 хувийг хайлуур жоншны хүдэр болон баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.

Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 33.08 хувь буюу 201.86 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 24.74 хувь буюу 150.97 тэрбум төгрөгийг Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсний арилжаа, 18.39 хувь буюу 112.23 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 12.03 хувь буюу 73.42 тэрбум төгрөгийг Баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 8.55 хувь буюу 52.15 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих чанаргүй нүүрсний арилжаа, 2.23 хувь буюу 13.64 тэрбум төгрөгийг Эрчим хүчний нүүрсний арилжаа, 0.97 хувь буюу 5.94 тэрбум төгрөгийг Чийг багатай хүрэн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

МХБ-н уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дүн жил бүрийн эхний хагаст (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

МХБ-ын ТОП-20 индекс 2025 оны 4-р сард энэ оны хамгийн доод ханш болох 46,334.87 хүрээд байсан бөгөөд үүнээс хойш 6.2 хувиар өсч 2025 оны эхний хагаст 49,246.2 нэгжид хүрлээ.

ТОП-20 компанийн 16 компанийн хувьцааны ханш 2025 оны эхний хагас жилийн байдлаар унасан үзүүлэлттэй байна. Хувьцааны үнэ буурсан 16 компанийг Монголын Хөрөнгийн Бирж ХК 25%-ийн уналтаар тэргүүлсэн бол араас нь Тавантолгой ХК 21% уналтыг үзүүлсэн байна. Оны эхнээс Сүү ХК нь ханш 54 хувь өссөн үзүүлэлтээр тэргүүлсэн бол Мандал Даатгал ХК 13 хувь, Ард Санхүүгийн Нэгдэл ХК 11 хувиар тус тус өссөн үзүүлэлттэйгээр удаалсан байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж